



JICA ALUMNI MONGOLIA

ЖАЙКА-ын Сургалт Төгсөгчдийн Холбоо

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бодь цамхаг, 7-р давхар, ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Утас: 325 939, 311 329 И-мэйл: jicamg-alumni@jica.go.jp

Цахим хаягууд: www.jaam.mn, <https://www.facebook.com/JICA Alumni Association Mongolia>

ЭНЭ ДУГААРТ

1. Зохион бүтээх сэтгэлгээг хөгжүүлэх нь
2. Сэргээгдэх эрчим хүчний мэргэжилтнүүд мэдлэг хамтран бүтээх хөтөлбөрт хамрагдана.
3. Египит улс боловсролын системдээ Япон маягийн сургалтын аргуудыг нэвтрүүлж байна.
4. Энэтхэгийн үндэсний цэцэрлэгт хүрээлэн ЖАЙКА-ын дэмжлэгээр “Дэлхийн хосолмол өв”-д бүртгэгдлээ.
5. Япон улсын гамшгийн удирдлагын туршлагаас хуваалцав.
6. “Эртэч яриа” өглөөний цуврал уулзалтын энэ удаагийн зочноор П.Наранбаяр оролцлоо.
7. ЖАЙКА-КОЙКА-ын сургалт төгсөгчдийн хамтарсан сургалт зохион байгуулагдлаа.
8. Японы томоохон хотууд

ЗОХИОН БҮТЭЭХ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ



2016 онд Монголын эдийн засгийн өсөлт 1 хувь ч хүрэхгүй байх магадлалтай, эдийн засгийн байдал хүндрэлтэй байгаа үед байгалийн баялагаас илүү тогтвортой хөгжилд чиглэсэн дотоодын үйлдвэрлэлийн боловсон хүчнийг бэлтгэх ажил нь нэн чухал байна.

2015 онд Говь-Алтай аймгийн Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн хувцас загварын тэнхимд багшаар томилогдож ирсэн сайн дурын гишүүн Ватанабэ нь хувцас үйлдвэрлэл, урлалын чиглэлээр Монгол залуу боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор тус төвийн оюутнууд болон оёдолын үйлдвэрлэл эрхэлдэг хүмүүст зориулан хувцас дизайн, оёдол эсгүүрийн хичээл зааж байна. Сурагчдад даашинз, үндэсний дээл хувцас, дүрэмт хувцас зэрэг олон төрлийн хувцас эсгэх, оёх аргыг заахаас гадна тэднийг илүү биеэ даасан бүтээлч, зохион бүтээх сэтгэлгээг нь хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Сайн дурын гишүүн Ватанабэ нь Говь-Алтай аймагт хувцас дизайн, оёдолын салбартаа олонд танигдан, нэр хүндтэй болж, өөр сургуулиудаас ч түүнийг ажиллуулах хүсэлт их ирдэг байна. Тэрээр цаашид Япон үндэстний нягт нямбай аливаа зүйлийг өөрсдөө зохион бүтээх гэсэн сэтгэлгээг илүү олон хүнд түгээхийг тулд чармайн ажиллана гэжээ.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ МЭРГЭЖИЛТНҮҮД МЭДЛЭГ ХАМТРАН БҮТЭЭХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАНА.



Энэ удаагийн “Мэдлэг хамтран бүтээх хөтөлбөр” буюу залуу удирдагчдийн бэлтгэх сургалтанд Монголын сэргээгдэх эрчим хүчний хөгжүүлэлт, бодлого боловсруулалтын чиглэлээр ажилладаг төрийн захиргааны залуу албан хаагч, инженерүүд хамрагдах юм.

Тус сургалтын оролцогчид Японы сэргээгдэх эрчим хүчний хөгжүүлэлт, ашиглалт дахь хөтөлбөр болон хэрэгжүүлж буй системийн тухай үндсэн мэдлэгт суралцаж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэртэй танилцан холбогдох хүмүүстэй санал солилцох замаар сэргээгдэх эрчим хүчний салбар дахь Япон улсын туршлага, тулгамдаж буй асуудал, эдийн засгийн үр нөлөө зэргийг судлах боломжтой. Мөн сургалтын үеэр Монгол улсын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал зэргийг хөндсөн зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, эх орондоо очоод хэрэгжүүлэх үүрэг даалгавар авдаг.

Сургалт 2016 оны 11 сард 18 хоногийн хугацаатай явагдах ба оролцогчид маань сургалтын үеэр Акита мужийн салхины цахилгаан станц, нарны цахилгаан станц, усан цахилгаан станц болон газрын гүний дулааны цахилгаан станцтай мөн танилцах юм.



ЕГИПИТ УЛС БОЛОВСРОЛЫН СИСТЕМДЭЭ ЯПОН МАЯГИЙН СУРГАЛТЫН АРГУУДЫГ НЭВТРҮҮЛЖ БАЙНА.

Япончууд хүүхдэд мэдлэг боловсрол олгоход танхимийн сургалтаас гадна хичээлээс гадуурх ажил нь хүүхдийн биеийн болоод танин мэдэх, оюуны хөгжилд сайн нөлөөтэй гэж үздэг байна. Энэ нь Япон маягийн боловсролын системийн үндэс суурийг бүрдүүлэгч хүчин зүйлийн нэгээхэн чухал хэсэг юм.

2015 оны 1 сард Бүгд Найрамдах Египет улсын Ерөнхийлөгч Абдул Фаттах Аль-Сиси нь Шинзо Абэ Ерөнхий сайдын тус улсад хийсэн айлчлалын үеэр Японы боловсролын системээс авах зүйл их байгааг дурдаад, Египетийн боловсролын системд Японы маягийн сургалтын арга барилыг нэвтрүүлэх болсноо түүнд хэлсэн юм. “Арабын хавар” хувьсгалын шуургаар засгийн эрхийн тогтворгүй байдал, эдийн засгийн уналтанд өртөөд буй тус улсад, тэдний ирээдүйг авч явах залуу үе, хүүхдийн боловсролд анхаарах нь хамгийн чухал асуудал болжээ.

Үүнтэй холбогдуулан, ЖАЙКА болон Египетийн Боловсрол, Шинжлэх ухааны яамнаас өнгөрсөн оны 10 дугаар сараас эхлэн хоёр бага сургуульд Японы сургуульд хэрэглэж заншсан гараа угаах, ээлжийн жижүүрт гарах, цэвэрлэгээ хийх зэргээс бүрдсэн 10 гаруй зүйлийн 5 минутын хичээлээс гадуурх ажлыг туршиж үзэхээр болсон байна.

Сурагчдын сэтгэлд хамгийн их нийцсэн нь ээлжийн жижүүр хийх. Учир нь Египетэд сурлага сайтай, тэргүүний

сурагчид л багшид туслах болон ангийнханыгаа удирддаг байв. Харин ээлжийн жижүүр хийснээр бүх хүүхэд тухайн ээлжинд гарсан өдрөө ангийнханаа удирдах эрхтэй болдог аж. Гэвч хүүхдүүд сургууль, анги танхимаа өөрсдөө цэвэрлэдэг болсон нь эцэг эхчүүдийн эсэргүүцэлтэй тулсан байна. Тэд хүүхдээр цэвэрлэгээ хийлгэж болохгүй, хүүхдийн хийдэг зүйл биш гэх мэт олон гомдол ирүүлж байсан ч, хүүхдүүд гэртээ хариад гэрийн цэвэрлэгээний ажилд туслах болсноор энэ хандлага өөрчлөгджээ.

Хоёр сургууль дээрх туршилтын ажил амжилттай хэрэгжсэн тул, цаашид олон сургууль дээр нэвтрүүлэхээр болжээ. Боловсрол, Шинжлэх ухааны яам болон ЖАЙКА энэ оны 9 сарын 19-нээс 22-ний хооронд тус улсын нийслэл Каир хотноо туршилтын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, 12 сургууль дээр ахин туршилтаа үргэлжлүүлэхээр болсон байна. Хэлэлцүүлэгт дунд сургуулийн багш нараас гадна Японы боловсролын системийг сонирхдог их сургуулийн багш нар гээд нийт 300 гаруй хүн хамрагдсан байна. Оролцогчдоос “Энэ аргыг сургууль дээрээ нэвтрүүлмээр байна” гэсэн санал их гарсан ба энэхүү Япон маягийн хичээлээс гадуурх ажлыг нэвтрүүлсэнээр хүүхдүүд сургууль дээрээ нийгмийн харилцаанд идэвхтэй оролцож, асуудлыг өөрсдөө шийдвэрлэх арга барилд сурахад чухал нөлөөтэй гэж үзжээ.



ЭНЭТХЭГИЙН ҮНДЭСНИЙ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН ЖАЙКА-ЫН ДЭМЖЛЭГЭЭР “ДЭЛХИЙН ХОСОЛМОЛ ӨВ”-Д БҮРТГЭГДЛЭЭ.



Энэтхэг улсын Канченджанга цэцэрлэгт хүрээлэн нь 2016 оны 7 сард зохион байгуулагдсан Дэлхийн өвийн хорооны 40 дүгээр хурлаар “Дэлхийн хосолмол өв”-д шинээр бүртгэгдлээ. Хосолмол өв гэдэг нь соёлын өв болон байгалийн өвүүд нэг дор орших газрыг хэлдэг ба Энэтхэг улс анх удаагаа энэ төрлийн өвд бүртгүүлжээ.

Канченджанга цэцэрлэгт хүрээлэнг Дэлхийн өв соёлд бүртгүүлэхийн тулд ЖАЙКА байгууллага 2009 оноос хойш биологийн олон янзын төрөл зүйлийг хамгаалах болон ойн менежментийн тал дээр анхаарч, дэмжлэг үзүүлэв. Мөн тогтвортой, эко аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд “Зүүн Гималайн биологийн олон янз байдлын халуун цэгийг хамгаалах үйл ажиллагаа”-г авч хэрэгжүүлсэн нь тус өвд бүртгүүлэхэд шаардагдах хамгийн чухал хүчин зүйлийн нэг байлаа.

Энэтхэгийн Сикким муж, Непалын зүүн хойд талд орших Канченджанга уул нь 8,586 метр өндөр ба Гималай болон Эверестийн дараагаар ордог дэлхийн 3 дахь өндөр уул юм. Канченджанга цэцэрлэгт хүрээлэн нь Канченджанга ууланд байдаг. Канченджанга гэдэг нь “Цасны таван эрдэнэс” гэсэн утгатай үг бөгөөд, нутгийн иргэд тус уулыг “Тэнгэр, газрын орон” гэж билэгшээн, ариун ном судрын бурхад ивээсэн газар хэмээн хүндэлдэг аж.

Сикким мужид Энэтхэг улсын бүх ургамлын төрөл зүйлийн 4/1 байдаг. Үзэсгэлэнт байгаль, нутгийн өвөрмөц

ёс заншилд түшиглэсэн эко аялал жуулчлал тус мужид их хөгжсөн. Гэвч, үүнийг дагаад онгон байгальд хор хөнөөлтэй, аюултай үр дагавар их гарч байгаа учир зайлшгүй байгаль хамгаалалын бодлого явуулах хэрэгтэй болсон байна. Энэ бүс нутагт орших Гималайн бүс нутаг биологийн олон төрөл зүйлийг хамгаалах шаардлагатай халуун цэг болж, ялангуяа Канченджанга цэцэрлэгт хүрээлэн биологийн төрөл зүйлээр хамгийн баялаг тул нэн түрүүн хамгаалах шаардлагатай болов.

Мөн нутгийн иргэдийн ихэнх нь ядууралд өртсөн тул бүс нутгийг хөгжүүлэх, байгаль орчинг хамгаалах бодлогыг хамтад нь хэрэгжүүлэх шаардлагатай тул ЖАЙКА байгаль орчин, ёс заншилд ээлтэй, тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого барин төсөл хэрэгжүүлжээ. Түүнчлэн дэлхийн өвд бүртгүүлэх баримт бичиг боловсруулахад өөрсдийн туршлага дээр үндэслэн тэр ажилд гар бие оролцон, дэмжлэг үзүүлэв. Сикким сужын Ойн газраас Канченджанга цэцэрлэгт хүрээлэн “Дэлхийн хосолмол өв”-д бүртгэгдсэнд ЖАЙКА-ын хамт олонд талархсанаа илэрхийлсэн байна.

ЖАЙКА-ын хамтын ажиллагаа нь 2022 он хүртэл үргэлжлэх ба, цаашид байгаль хамгаалах, үндэсний ёс заншлийг хадгалж үлдэх, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлд түлхүү ажиллах болно гэдгээ мэдэгджээ.





ЯПОН УЛСЫН ГАМШГИЙН УДИРДЛАГЫН ТУРШЛАГААС ХУВААЛЦАВ.

Холбооны гишүүн Ё.Жаргалсайхан “Follow up” сургалт семинарын төслийн шалгууралтын хүрээнд “Сурсан мэдсэнээ бусадтайгаа хуваалцах” зорилгоор “Японы гамшгийн удирдлагын туршлага, Монгол Улсад нэвтрүүлэх боломж” семинарыг 2016 оны 9 дүгээр сарын 28-нд Онцгой байдлын ерөнхий газарт зохион байгууллаа. Семинарт гамшгаас хамгаалах асуудалд хамаарч оролцдог бүхий л байгууллагууд, яамд, агентлаг, улсын албадын 70 гаруй хүн оролцлоо.

Энэхүү семинарт Япон Улсын Засгийн газрын гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоо /Ё.Жаргалсайхан/, Засгийн газрын онц чухал барилга байгууламжийн барилгын чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлын үзлэг шалгалт, дахин төлөвлөлт /З.Энх-Оргил, Д.Жаргал, Г.Энхтуяа/, Гамшгаас хамгаалах, үр дагавар, хор хохирлыг арилгах ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудын оролцоо, Гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах баг /

ТЕС FORCE/-ын үйл ажиллагаа /З.Баттулга/, Токио хотын гамшгийн нөхцөл байдал, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцоо /Ё.Жаргалсайхан/, Гамшгаас хамгаалах олон нийтийн сургалт, дадлагын төвийн үйл ажиллагаа /Р.Хишигбаатар/, Японы Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй сургуулийн барилга байгууламжийн гамшгаас хамгаалах арга хэмжээний төлөвлөлт /Р.Балжинням/ илтгэлүүдийг сургалтанд оролцогчдод танилцуулсан.

Эдгээр илтгэлүүдийн дараа сургалтаас олж авсан мэдлэг, Японы сургамж, туршлагыг Монголд нэвтрүүлэх боломж, арга замыг ярилцаж, өргөн хэлэлцүүлэг боллоо. Үүний дараа семинарын үр дүнг үнэлж дүгнээд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой санал зөвлөмжийг гаргаж, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлд танилцуулахаар болов.





“ЭРТЭЧ ЯРИА” ӨГЛӨӨНИЙ ЦУВРАЛ УУЛЗАЛТЫН ЭНЭ УДААГИЙН ЗОЧНООР П.НАРАНБАЯР ОРОЛЦЛОО.

ЖАЙКА-ын СТХолбооноос Монгол, Япон хоёр орны хоорондын харилцаанд гүүр болж байдаг эрхэмүүдийг оролцуулсан “Эртэч яриа” өглөөний хоёр дахь удаагийн уулзалтыг 2016 оны 10 сарын 12-ны 7:00-8:30 цагт ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн газрын уулзалтын танхимд зохион байгууллаа.

Энэ удаагийн зочноор Олон улс судлалын доктор Пүрэвсүрэнгийн Наранбаяр оролцлоо. Тэрээр 2000-2012 онд Байгаль орчны яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Аялал жуулчлалын газарт, 2012 оноос Монгол-Японы боловсролын харилцаанд гүүр болсон Шинэ Монгол сургуулийн захирлаар ажиллаж байна. П.Наранбаяр нь төрийн албанд ажиллаж байхдаа Японы ерөнхий сайд Хашимото болон Японы ханхүүгийн Монгол дахь айлчлалын орчуулагч, “Шар шороон шуурга” төслийн санаачлагч, Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх олон төсөлд гар бие оролцож Монгол-Японы хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлд өөрийн хувь нэмэрээ оруулсаар ирсэн байна.

Мөн тэрээр өөрийн сонирхлийн дагуу Мэйжигийн үеийн 2 том зохиолчийн нэг Мори Оогайгийн “Зэрлэг галуу”, Окада Хидэхиро “Дэлхийн түүх мэндэлсэн нь”, Үмэсао Тадао “Монгол угсаатныг сурвалжилсан нь”, ЭМОС клубтэй хамтран Инамори Казүогийн “Амжилтанд хүрэх гал эрмэлзлэл” гэх мэтийн олон бүтээлийг япон хэлнээс монгол хэлнээ орчуулжээ.

Бидний энэ удаагийн уулзалт чөлөөт ярилцлага хэлбэрээр өрнөсөн ба холбооны ерөнхий нарийн бичгийн дарга



Т.Золбоот болон ирсэн зочид маань түүнээс “Яагаад Япон судлалыг сонгох болсон, Шар шороон шуурга төслийн талаар, түүний орчуулсан зохиол бүтээл, мөн Шинэ монгол сургууль болон хүүхдийн боловсролын талаар” өргөн хүрээнд олон асуулт тавьж байлаа. Зочин маань бидний асуултанд маш сонирхолтой сайхан хариулт өгч, холбооны гишүүдтэй дотно сайхан яриа өрнүүлээ.

Бидний зохион байгуулж буй үйл ажиллагааг дэмжин, өглөө эртлэн босч ирсэн оролцогчид болон бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн П.Наранбаяр захиралдаа талархалаа илэрхийлэхийн ялдамд цаашдаа Монголын олон сайхан үрсийг зөв хүн болгон хүмүүжүүлэх үйлсэд нь улам их амжилт гаргахыг ерөөл өргөө.

Ярилцлагын тоймыг www.jaam.mn сайтаас үзнэ үү.



ЖАЙКА-КОЙКА-ЫН СУРГАЛТ ТӨГСӨГЧДИЙН ХАМТАРСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

ЖАЙКА-ын сургалт төгсөгчдийн холбооны гишүүн, Монбиофарм ХХК-ийн лабораторийн эрхлэгч Г.Батзул, МХЕГазрын ХАБҮЛЛабораторийн менежер Т.Сайнжаргал, шинжээч Б.Оюунчимэг, КОЙКА-ын сургалт төгсөгчдийн холбооны гишүүн, ХХААХҮЯамны мэргэжилтэн Д.Хишигжаргал нар хамтран 2016 оны 09 сарын 30-ний өдөр “Хүнсний аюулгүй байдал: Үр тариа, малын тэжээл дэх микотоксины бохирдол, эрсдэлийн судалгаа, микотоксин илрүүлэх шинжилгээний аргууд “ сэдэвт онол, лабораторийн дадлага ажил хосолсон 1 өдрийн сургалтыг ЖАЙКА-ын сургалт төгсөгчдийн холбоо, КОЙКА-ын сургалт төгсөгчдийн холбоо болон Монбиофарм ХХК-ний дэмжлэгтэйгээр зохион байгууллаа.

Хүнсний аюулгүй байдал чухлаар тавигдаж буй өнөө үед лабораторийн шинжээч, мэргэжилтнүүдэд хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг тодорхойлох шинжилгээний арга зүйг эзэмшүүлэх нь нэн тэргүүний ажил болоод байна. Учир нь Олон Улсын төсөл хөтөлбөр, сургалт семинарт төрийн байгууллагуудын шинжээч, мэргэжилтнүүд түлхүү хамрагддаг бөгөөд Монгол улсын хүнсний салбарыг нуруун үүрч буй хувийн хэвшлийн хүнс, малын тэжээлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн шинжээч мэргэжилтнүүд мэдлэг мэдээлэл, зохион байгуулалт, идэвхи сааначилга, санхүүгийн боломж тааруу зэрэг шалтгаануудаас болоод хамрагдаж чадахгүй байна гэж үзэж байна.

Иймд бид энэхүү семинарын хүрээнд үр тариа, малын тэжээл тарьж ургуулдаг, үйлдвэрлэдэг, түүхий эд болгон ашигладаг хувийн хэвшлийн хүнс, малын тэжээлийн үйлдвэрүүд, аж ахуйн нэгжүүдийн лабораторийн шинжээч, мэргэжилтнүүдийг хамруулахыг зорьсон бөгөөд нийт хувийн хэвшлийн 19 аж ахуйн нэгж, компани, төрийн 4 байгууллагын хүнсний аюулгүй байдлын 38 шинжээч,

лабораторийн болон чанарын хяналтын мэргэжилтнүүд хамрагдсан байна.

Сургалтад хамрагдсан шинжээч, мэргэжилтнүүдэд хүнсний аюулгүй байдал, төрөөс баримталж буй бодлого, хөгц мөөгөнцөрийн ангилал, таньж тодорхойлох шинжилгээний сүүлийн үеийн арга аргачилал, микотоксины тухай, тэдгээрийн хүний эрүүл мэндэд учруулах эрсдэлийн тухай, микотоксин илрүүлэх шинжилгээний аргууд, микотоксины эрсдэлийн үнэлгээний ажлын талаархи мэдээлэлийг лекц хэлбэрээр заасан, мөн микотоксин илрүүлэх шинжилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмж, оношлуурын талаархи мэдлэг, мэдээлэлийг электрон болон цаасан хэлбэрээр тарааж өгсөн бөгөөд ингэснээр хүнсний аюулгүй байдал болон микотоксины тухай дэлгэрэнгүй мэдлэг, мэдээлэлтэй болсон гэж итгэж байна. Сургалтын өдрийн үдээс хойш Монбиофарм ХХК-ийн дэргэдэх Евростандарт лабораторид Германы R-Biopharm компани үйлдвэрлэсэн RIDA@SCREEN FAST AFLATOXIN B1 оношлуурыг ашиглан улаан буудайн дээжинд ELISA аргаар Афлатоксин B1 тодорхойлох дадлага ажил-туршилтын шинжилгээг сургалтад оролцогч бүр хийлээ. Ингэснээр микотоксин тодорхойлох шинжилгээний ELISA арга зүйг эзэмшин тодорхой туршлага, мэдлэгтэй болсон гэж үзэж байна.

Сургалтад хамрагдсан шинжээч, мэргэжилтнүүд маань сургалтаас олж авсан мэдлэг мэдээллээ ашиглаад өөрийн аж ахуйн нэгж болон компанидаа микотоксин тодорхойлох шинжилгээний аргыг нэвтрүүлэх, микотоксин илрүүлэх, микотоксины эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байна. Ингэснээр хүнсний аюулгүй байдлын асуудал тэр дундаа микотоксиноос шалтгаалсан өвчлөл, эрсдэл бага боловч буурах байх гэж бид найдаж байна.





ЯПОНЫ ТОМООХОН ХОТУУД

Дугаар №18-ийн үргэлжлэл

Японд аялахдаа очиж үзэхийг санал болгох хотуудыг хүн амын тоогоор нь дарааллуулан танилцуулья.

КООБЭ

Хёго аймгийн нийслэл Кообэ (1,5 сая хүн амтай) хот нь Японы арван том хотын нэг бөгөөд нэг талдаа далайгаар нөгөө талаараа Рокко уулаар хашигдсан байдаг. Кообэ нь олон зууны турш Японы чухал хот байсан төдийгүй Эдогийн төгсгөл үед гадаад худалдаа эрхэлдэг боомт хот байсны ачаар орчин үеийн хүчирхэг, хөгжил дэвшилтэй хот болсон байна.

1995 оны 1-р сард болсон Ханшин-Аважигийн их газар хөдлөлтийн үеэр 5000 гаруй хүн амиа алдаж, тус хотод олон

арван барилга нурж, ихээхэн гарз хохирол учирсан байна. Гэвч 10 хүрэхгүй жилийн дотор тус хот дахин баригдаж, газар хөдлөлтийн ор мөр бараг мэдэгдэхээргүй болсон байна.

Та энэ хотод айлчилснаар Акаши Кайкёо хэмээх дэлхийн хамгийн урт гүүрийг гатлаж, Кообэ Харборланд дахь зугаа цэнгээний болон худалдааны төвүүд, Нанкинмачи дахь хятад хороолол, Мэрикэн парк дахь Кообэ цамхагийг үзэж сонирхож болно. Мөн хотоос холгүй орших Арима халуун рашаанд орж, Рокко ууланд гарч шөнийн Кообэ, Осака хотын үзэмжийг тольдоход илүүдэхгүй. Зул сарын баярын үеэр гэрлэн чимэглэлээр гоёдог тус хотыг жуулчид ихээр зорьдог.



Акаши Кайкёо хэмээх дэлхийн хамгийн урт гүүр



Мэрикэн парк дахь Кообэ цамхаг

КЁОТО

Кёото хот нь 794 оноос 1868 он хүртэл Японх улсын нийслэл, эзэн хааны амьдран суудаг хот байсан билээ. Тус хот нь 1,4 сая хүн амтай Япон улсын 7 дахь том хот юм. Олон зууны турш Кёото хот нь дайн тулааны хөлд үрэгдэж байсан боловч түүхийн үнэ цэнэтэй хот гэдгээр нь бөмбөгдөлтөнд өртөөлгүй, олон арван хүний хоргодох газар болж байжээ. Японы соёлын өв болсон олон зуун сүм, дугана, хааны ордны барилгууд Кёото хотыг өдий хүртэл чимэн, олон мянган жуулчдын очих дуртай газрын нэг болгосон байна.

Кёото хотын төвд Гион хэмээх гудамжаар алхаж, аз нь таарвал майкотой¹ зургаа татуулан, япон маягийн чамин тансаг бараа бүтээгдэхүүн худалдан авахын хажуугаар цайны ёслол, Японы уламжлалт жүжиг, дуурийг сонирхон, япон хоол зооглож үзээрэй. Тус хотын жуулчид их очдог сүм, их очдог сүм, дуганыг нэрлэвэл: Кинкакүжи буюу Алтан сүм (алтаар бүрсэн үзэсгэлэнт сүм), Гинкакүжи буюу Мөнгөн сүм, Киёмизүдэра, Хааны ордон, Санжүсангэндо, Нижо цайз, Хэйан сүм, Ясака дугана зэрэг юм. Кёотогийн галт тэрэгний

төв өртөө нь орчин үеийн шилдэг өртөөнүүдийн нэг бөгөөд тус хотод Арашиямагийн үзэсгэлэнт газар, Күрама халуун рашаан зэрэг алжаал тайлах тааламжтай газрууд байдаг.



Алтан сүм

¹ Залуу гэйша, гэйша болохоор суралцаж буй бүсгүйг Кёотод майко хэмээнэ.

Эх сурвалж: ЭМОС Ном "Япон хөтөч". УБ 2008